

МОНГОЛ УЛС
ӨМНӨГОВЬ АЙМАГ



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Хянасан: **Төсвийн Ерөнхийлөн захирагч, Аймгийн Засаг дарга**

..... /Р.Сэддорж/

(албан тушаал) (гарын үсэг)

2021.06.09 (огноо)

Тэмдэг.....

Төлөвлөгөөг тайлагнасан: **Төсвийн Шууд захирагч, Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч**

..... /Д Энхмандах/

(албан тушаал) (гарын үсэг)

2021.06.09(огноо)

Тэмдэг

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хэрэгжээгүй бол тайлбар	Гүйцэт гэлийн хувь
Стратегийн зорилго-1: Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх, эрүүл зөв дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх замаар дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд оршино.							
1.1	Зорилт 1.1. Халдварт өвчний тархалт, сэргийлэлт бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авах, дархлаажуулалтын арга хэмжээг хүртээмжтэй болгож, халдварт өвчний тархалтыг бууруулна.						
	Арга хэмжээ 1.1.1. Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх, тандах чиглэл хөтөлбөр, төслийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах	Улсын төсөв	Халдварт өвчний тохиолдол 10000 хүн амд Товлолын дархлаажуулалтын хувь	2474,1 98,6	2100 Суурь үзүүлэлтээс бууруулахгүй.	Улирлын томуугийн эдийн засгийн дарамтыг судлах судалгаанд 0-5 нас 34, жирэмсэн 33, 65-с дээш нас 33 нийт 100 хүнээс авах судалгааг аймгийн төвд зохион байгуулсан ба 2022 оны 1-р улиралд нийт томуугийн 111 сорьцыг ХӨСҮТ-ийн Томуугийн лабораторит хүргүүлснээс 70-80% амьсгалын замын синтициал вирус давамгайлсан томуугийн дэгдэлт үүссэн. Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн эмч ажилчдыг идэвхжүүлэх зорилгоор Томуугийн тандалтын нэгжийн багтай хамтран ажиллаж, БОЭТ, 3 ӨЭМТ-д дэмжлэг хяналт хийж, мэдлэг сэргээх сургалтыг зохион байгуулсан. Өмнөговь аймгийн хэмжээнд 2022 оны 6 сарын 07-ны байдлаар нийт халдварт өвчний 11573 тохиолдол бүртгэгдсэн ба 10000 хүн амд 1618,7 промил байгаа нь хүрэх түвшингээс 1,2 /77%/ дахин бага байна. Нийт халдварт өвчний 99,2%-г ковид 19-ийн халдвар эзэлж байгаа ба үүний 45% нь уул уурхай, нүүрс тээвэртэй холбоотой бүртгэгдсэн байна. Тарилгатай халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй. Дархлаажуулалтын үндэсний товллолын дагуу товллолын вакцины нөөцийг хангаж 97.8%-ын хамралттай байна.	100

1.2.	Арга хэмжээ 1.1.2. Коронавируст халдвар /КОВИД-19/ сэргийлэх, тэмцэх, арга хэмжээг зохион байгуулна.	Орон нутгийн төсөв	Коронавирус т халдварын өвчлөл 10000 хүн амд эзлэх хувь	2449.1	2000.0	Эрүүл мэндийн сайдын болон Улсын онцгой зомиссын тушаал шийдвэрүүдийг тус тус эмнэлгүүдэд танилцуулан арга зүйгээр ханган, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. ЭМБ- уудад 7 хоног бүрийн эргэн мэдээллийг хүргүүлж, анхаарал татсан сумдад мэргэжил арга зүйн зөвлөгөөг тасралтгүй өгч байна. Эхний 6 сарын байдлаар 14 сум, 3 өрх, БОЭТ-д нийт 3 зөвлөмж хүргүүлж, халдварын дэгдэлт гарахаас сэргийлж бүх шатны ЭМБ-уудыг тандалтын шинжилгээ хийхийг зөвлөөд байна. 2 хилийн боомтын ажилчид, нүүрс тээврийн жолооч нараас хувилбар илрүүлэх шинжилгээнд сорьц авах ажлыг хийж байна. Аймгийн хэмжээнд 2022 оны 6 сарын 6-ны байдлаар 11786 тохиолдол бүртгэгдсэн ба өвчлөл Оюу толгой ХХК уурхай, Цагаанхад хилийн боомтны нүүрс тээврийн жолооч нарын дундах өвчлөл буурахгүй бүртгэгдсэн хэвээр байна. 10000 хүн амд 1606,1 промил байгаа нь суурь үзүүлэлтээс 1,5-р буурсан, хүрэх түвшингээс бага байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн ажилтнуудыг 1,2 тунд 99,7%, нэмэлт тунд 83% хамруулсан.	100
	Арга хэмжээ 1.1.3. “Эрүүл элэг” хөтөлбөрийг хэрэгжүүлж элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж илэрсэн өвчлөлийг эмчилгээнд бүрэн хамруулах, В эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулна.	180.0	Элэгний хавдараас сэргийлэх эрт илрүүлгийн хувь	40.0	60.0	Эрүүл элэг орон нутгийн дэд хөтөлбөрийг 3 зорилтийн хүрээнд 25 хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөн батлуулж, анхан шатны эрүүл мэндийн байгууллага бүрт хүргэн арга зүйгээр ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд элэгний эрт илрүүлэгт хамрагдах 15-с дээш насны 24288 гаруй иргэдийн судалгааг гаргаж эрт илрүүлэлт 4531 хүн шинээр хамрагдаж С вирус- 163, В вирус- 145 тохиолдол бүртгэгдэж, 8 хүн ачаалал тоолох шинжилгээ хийлгэж үүнээс С вирус тоологдсон/идэвхтэй хүн 2, В вирус тоологдсон/идэвхтэй хүн 1 илэрч эмчилгээнд хамрагдах шаардлагатай 3 хүнээс 2 хүн эмчилгээ хийлгэсэн. В вирусийн дархлаажуулалтанд шинээр 927 хүн тун хийсэн 2022 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвд элэгний хатуурал, хавдрыг эрт илрүүлэх зорилготой багаж, тоног төхөөрөмжийн хангалтыг хийхээр төлөвлөн худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Элэгний хавдараас сэргийлэх эрт илрүүлгийн хамрагдалтын хувь 18,6 буюу гэрээний хэрэгжилт 31% байна.	31

	Арга хэмжээ 1.1.4. Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх цогц үзлэг, хавьтлын үзлэг, сорьц тээвэрлэлтийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.	Төсөл хөтөлбөр	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин 10 000 хүнд	1.5	1.5	2022 онд сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр жилийн болзолт уралдааны удирдамж, “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлье” уриан дор 2022 оны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулан бүх эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Мандал-Овоо суманд хавьтлын үзлэг зохион байгуулхаар удирдамжийг батлуулан бэлтгэл ажлыг хангаад байна. Манлай суманд 350 хүнээс асуумж, рентген зураг, сорьц авах, үзлэг оношлогоо хийснээс хуучин сүрьеэтэй 10 хүнийг үзэж, ар гэрийн 16 хүнийг хавьталын үзлэгт хамруулав. Уушгины бус сүрьеэ-1, 14 хүний 24 сорьц шинжилгээ авсан. Сүрьеэгийн сэжигтэй тохиолдол илрээгүй байна. 2022 оны эхний 6 сарын байдлаар 6 идэвхитэй сүрьеэ илрүүлсэн ба сорьц тээвэрлэлт 35 хүний 25 удаагийн давтамжтай тээвэрлэж халдвартай хэлбэрийн 1 сүрьеэ илрүүлсэн байна. Сүрьеэгийн өвчлөл 10000 хүн амд 0,8 промил байгаа нь хүрэх түвшингээс 0,7-р бага байна.	55
	Арга хэмжээ 1.1.5. Зоонозын халдварт өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан зохион байгуулж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	Улсын төсөв	Хачигт халдвар тохиолдол 10000 хүн амд	0.2	0.1	2022 онд ЗӨСТ-тэй хамтран эмнэлгийн мэргэжилтнүүдэд цахим сургалт зохион байгуулсан. Хүн мал амьтны эрүүл мэндийг хамгаалах бодлогын үнэлгээний салбар хоорондын хэлэлцүүлэг 6 сард зохион байгуулагдах тул ЭМГ,ЗӨСТ-с цаашидын төлөвлөлтийг хийхээр ажиллаж байна Зоонозын халдварт өвчнөөс 2022 оны эхний 6 сарын байдлаар Хачигт риккетсиозын 1 тохиолдол батлагдаж, хяналтад авч, эмчилгээнд оруулсан. Хачигт халдварын тохиолдол 10000 хүн амд 0,1 промилиг эзэлж байна.	50
	Зорилт 1.2. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, сэргийлж болох эндэгдлийг иргэд, хамт олны оролцоотой бууруулж, нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг 1:эрчимжүүлэх						
	Арга хэмжээ 1.2.1. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл тухайлбал, элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэлт өвчний эрт илрүүлэх үзлэгт хамралтыг нэмэгдүүлэх.	Улсын төсөв	Эрт илрүүлгийн дундаж хувь	45.4	55.0	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн артерийн даралт ихсэх өвчин илрүүлэх үзлэгт 3848 чихрийн шижин илрүүлэх үзлэгт 3973, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 471, хөхний хавдар илрүүлэх үзлэгт 4639, элэгний эрт илрүүлэгт 4042 хүн хамрагдаж хамрагдвал зохих иргэдийн 51 хувь халдварын бус үзлэгт, 49 хувь нь бусад урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Эрт илрүүлэгт хамрагдсан иргэдээс цусны даралт ихсэх өвчинтэй 13, чихрийн шижинтэй 15 хүн шинээр	92,7

					оношлогдож хяналтад авсан. Өвчнийг эрт илрүүлэх, багц үзлэгт хамрагдах мэдээлэл сурталчилгааг ЭМТ-үүдийн цахим хаягаар дамжуулан иргэдэд хүргэж байна. Халдварт бус өвчний эрт илрүүлгийг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ” сэдэвт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах зөвлөгөөг тасралтгүй явуулж байна. Халдварт бус өвчний эрт илрүүлгийн дундаж хувь 51 байна.	
Арга хэмжээ 1.2.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд “Бүх нийтийг хамруулах”, “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримтлан, алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын урьдчилан сэргийлэх үзлэг”-г зохион байгуулах	ОНТөсөв 250.0 сая төг.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	33.1	38.1	Орон нутгийн санхүүжилтээр Аймгийн хэмжээнд “Явуулын үзлэг”-ээр 14 сумын 12927 хүн хамруулахаар төлөвлөснөөс 4 сумын 1848 хүн, “Явуулын оффисс” арга хэмжээнд 2 сумын 234 хүн тус тус хамрагдсан байна. Зорилтот түвшиний 42%-д хүрсэн байна. Одоогийн байдлаар 43.0 сая төгрөгийг төлөвлөн зарцуулаад байна. Бүх нийтийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах үйл ажиллагаа 5 сараас эхлэн явагдаж байгаа ба анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд ажлын хэсэг гарган эрт илрүүлэг үзлэгийг 0-17 насанд, БОЭТ 18-с дээш насанд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна. 6-р сарын 09-ны өдрийн байдлаар 0-17 насны эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 25143 хүүхдээс 12.8% буюу 3206 хүүхдийг, насанд хүрэгчид 341 хүнийг /0,8%/ хамруулаад байна.Эрт илрүүлэг үзлэгтэй холбоотой Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргасан 12 төрлийн постер мэдээллийг орон нутгийн 18 цахим мэдээллийн групп болон Эрүүл мэндийн газрын пэйж хуудсаар олон нийтэд сурталчилж 7 хоног бүрийн даваа гаригт тайлагнаж нийт 28 удаагийн тайланг холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.	42
Арга хэмжээ 1.2.3. “Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, амны хөндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх.	ОНТөсөв 180.0 сая төг	Амны хөндийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо	18000	21000	“Эрүүл шүд” Хөтөлбөрийн хүрээнд шүдний эмчгүй сумдад үзлэг эмчилгээ хийх зорилгоор Нүүр ам судлалын сургуульд орон нутагт эмч ажиллуулах хүсэлт хүргүүлсэн. Шүдний 7 кабинетад шаардлагатай эм урвалж бодис болон зарим тоног төхөөрөмжийг 84.0 сая төгрөгөөр захиалгыг хийсэн. Тусгай хэрэгцээт 216 иргэнийг шүдний үзлэг эмчилгээнд хамруулхаар 18.0 сая төгрөгийн төсөвтэй удирдамж тооцоо гарган ажиллаж байна. Өнө-орших өрхийн эрүүл мэндийн төв дээр шинээр шүдний	27,6

						кабинет нээхээр төлөвлөн, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. 2022 оны 3 дугаар улирлаас эхлэн Энхийн хүслэн, Шимбилэг өрхийн эрүүл мэндийн төвийн шүдний кабинетийг хэвийн ажиллагаанд оруулж, шаардлагатай хүний нөөц, эм эмнэлгийн хэрэгслийн хангалтыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа шүдний кабенинтуудаар нийт 5800 /гэрээний 27,6%/ хүн амны хөндийн тусламж үйлчилгээ авсан байна. Мөн БОЭТ-д ажиллах шүдний 2 эмчийн байрны асуудлыг АЗДТГ-аас шийдвэрлэхээр болсон.	
	Арга хэмжээ 1.2.4. Сургуулийн өмнөх болон сургуулийн хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн чанар хүртээмжийг сайжруулах, “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын оролцоог хангах	Улсын төсөв	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	Улсын хэмжээнд ЕБС-ийн 1-5 дугаар ангийн сурагчдад үдийн цай өгч байсныг аймгийн хэмжээнд 2021-2022 оны хичээлийн шинэ жилд 6 дугаар ангийн сурагчдад үдийн хоол өгч эхэлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн дагуу 2021 оны 09 дүгээр сарын 1-ээс “Үдийн хоол” болгон өөрчилөн өгч эхэлсэнтэй холбоотойгоор Мэргэжлийн хяналт, Боловсрол шинжлэх ухааны газар болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран тогтмол хяналт тавин ажиллаж байна. 2021-2022 оны хичээлийн жилд 22 сургуулийн 6-р ангийн 1392 сурагчдад 10 дугаар сарын 18-аас эхлэн 1500 төгрөгөнд багтаан үдийн хоол өгөх ажлыг холбогдох байгууллагууд зохион байгуулан ажиллаж байна. 10 сургуулийн гал тогоонд 300 гаруй сая төгрөгний тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж, сурагчид ая тухтай орчинд, эрүүл хоол хүнс хэрэглэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.	100
	Арга хэмжээ 1.2.5. “Сүү тараг” хөтөлбөрийг хэрэгжүүлж хүүхдийн жингийн алдагдал, эрсдэл бодисын дутагдлыг бууруулна	ОНТөсөв 250.0 сая төг	Зорилтод бүлгийн хүүхдийн хамралтын хувь	80%	90%	“Сүү тараг” хөтөлбөр нь аймгийн ИТХ-ын 86 дугаар тогтоолоор 2021 оны 06 сарын 17-ны өдөр батлагдаж 2 дахь жилдээ хэрэгжүүлж байна. 2022 оны хөтөлбөрийн үйл ажиллагаа 04 сарын 03 ны өдрөөс 3 суманд хэрэгжүүлж эхэлсэн ба 6 сарын 1-ны байдлаар 15 суманд үйл ажиллагаа 100% хэрэгжиж байна. Аймгийн хэмжээнд 15 сумын 6-12 сартай хүүхэд- 1299, 2 хүртэлх насны ихэр- 48, 12 хүртэл насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд – 193, жингийн алдагдал, өсөлтийн хоцрогдолтой- 177, нийт 1717 хүүхдийг судалгаагаар зорилтод бүлэг болгон авч бүртгэл судалгаа хийгдэж, сүү тараг хөтөлбөрийн дэвтэр	50,9

						тарагдсан. Хөтөлбөр 1717 хүүхэд хамрагдах ёстойгоос одоогийн байдлаар 875 хүүхэд хамрагдаж 50,9%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Малчин өрхийн хүүхдүүд/ 5,8%/, өөр хот аймаг суманд байгаа хүүхдүүд /3,1%/, өөрийн хүсэлтээр сүү тараг авахгүй байгаа хүүхэд /1,8%/ хөтөлбөрт хамрагдаагүй байна. Даланзадгад, Ханхонгор сумд хөтөлбөрийн үйл ажиллагаа эхэлж байгаа тул хүүхдээ бүрэн хамруулж дуусаагүй 39,0%-тай байна. Холт Интернэшнл ТББ-ын Монгол улс дахь төлөөлөгчийн газартай хамтран “Сүү тараг хөтөлбөр” ийн хүрээнд бага насны хүүхдийн хөгжлийн хяналт хийх программ ашиглалтын сургалт зохион байгуулан мэдээллийн сан үүсгэн хүүхдийн хөгжлийг хянаж байна.	
	Арга хэмжээ 1.2.6. Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндэд анхаарч, охидын жирэмслэлт, төрөлт, үр хөндөлтийг бууруулах арга хэмжээг зохион байгуулах	Төсөл хөтөлбөр	Тусламж үйлчилгээ үзүүлсэн өсвөр үеийнхний тоо	700.0	1000.0	Эхний хагас жилийн байдлаар өсвөр үеийн асуудал хариуцсан мэргэжилтэнг орон тоогоор ажиллуулж, тодорхой төсөвтэй төсөл хөтөлбөрт зорилт үйл ажиллагаануудыг тусган 5 байгууллагын оролцоог ханган ажиллаж байна. Өсвөр үе залуучуудад чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ хүргэдэг ӨҮК /Өсвөр үеийн кабинет/-ийн үйл ажиллагаанд НҮБ, Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр 4 кабинетийн үйл ажиллагаанд багийн үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн. Мөн хэрэглэгчийн судалгааг хийсэн ба ӨҮК-ийн үйл ажиллагаа 53%-тай дүгнэгдсэн. Охидын жирэмслэлт, үр хөндөлтийг бууруулах чиглэлээр ЭМБ-ын эмч, мэргэжилтнүүдэд 4 удаагийн сургалт зохион байгуулж, 51 хүн хамрагдсан бол охидын жирэмслэлт, үр хөндөлтийг бууруулахаар 6 байгууллага, эцэг эхийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг нэвтрүүлэг зохион байгуулсан. Мөн 4 өсвөр үеийн кабинетаар дамжуулан 2356 хүүхдэд цахимаар болон танхимаар ЭМ-ийн боловсрол олгосон байна. Өсвөр насны 1 000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин өнгөрсөн оноос 3-р буурсан байна.	100
	Арга хэмжээ 1.2.7. Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, дэлгэцийн донтолт, хараа сулрах, сэтгэцийн эмгэгээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах,	Төсөл хөтөлбөр	Арга хэмжээний гүйцэтгэлийн тоо хувь	2-100	5-100	Эхний хагас жилийн байдлаар сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр онош тавигдаж, сэтгэл заслын үйлчилгээ авсан өсвөр үеийн 44 тохиолдол байна. Өсвөр үеийнхэнд зориулсан сэтгэцийн ЭМ-ийг дэмжих арга хэмжээг “Эрүүл Өмнөговь” арга хэмжээний хүрээнд одоогоор 4 суманд ажиллаж, 6-17 насны 61 хүүхдэд сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг, зөвлөгөө өгч ажилласан байна. Мөн	40

	хамтын ажиллагааг хангаж хамтран ажиллах					СЭМҮТ-тэй хамтран 15 сумын өсвөр үеийн асуудал хариуцсан 60 эмч мэргэжилтэнд “Өсвөр үеийнхэнд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” сэдэвт арга зүйн сургалтыг зохион байгуулж, 2019 онд Өмнөговь аймгийн Өсвөр үеийнхний дунд хийсэн сэтгэцийн эрүүл мэндийн судалгааны дүнг танилцуулж, анхаарах асуудлыг хэлэлцсэн. Нийт төлөвлөсөн 5 ажлын 2 нь 100% гүйцэтгэлтэй хийгдсэн.	
	Арга хэмжээ 1.2.8. Иргэдийн дунд сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийг өргөжүүлэх	Улсын төсөв Төсөл хөтөлбөр	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	1500	2200	“Сархадгүй сонголт” аяны арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, сумдад уриалсан бөгөөд 24 байгууллагын хамруулан, 14 байгууллага идэвхитэй оролцож, 25 хүнийг архинаас гаргах эмчилгээнд хамруулсан байна. Мөн 7 электрон сурталчилгааны самбарт архины хэрэглээ, сэтгэцэд нөлөөлөх байдлыг харуулсан постер 2 сар байрлуулсан бол ЭМГ-ийн болон оролцогч байгууллагын пэйж хуудсанд нөлөөллийн сурталчилгааны материалыг байрлуулж нийт 16800 хүний хандалт авсан байна. “Эрүүл Өмнөговь” арга хэмжээний хүрээнд 4 суманд нарийн мэргэжлийн эмч нарын баг очиж үзлэг хийсэн ба мэдрэл сэтгэцийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт нийт 448 хүн хамрагдсанаас 38,4% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай байсан бөгөөд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна. Мөн иргэдэд үйчлх эрүүл мэндийн нээлттэй өдөрлөгийн хүрээнд 1500 иргэнд сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах мэдлэг олгох лекц уншуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	21,5
	Арга хэмжээ 1.2.9. Ахмадуудын дунд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Улсын төсөв	Зорилтот бүлгийн хамрагдсан хувь	50 хувь	4226 ахмадын - 80 хувь / 3380/	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын дагуу ЭМД-аас төлөх Ахмадын сэргээн засах тусламж, үйлчилгээ 1,624,000₮ , уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний 517,650₮ болсон. Энэ нь уламжлалт, сэргээн засах чиглэлээр ахмадын амралт, сувилалын үйлчилгээг бодлогоор дэмжих үндэс болсон ба энэ чиглэлээр Сэврэй сумын эрүүл мэндийн төв Хонгорын голд байрлах “Нүдэн булаг” ахмадын амралт сувилалын үйлчилгээг өргөжүүлэн эхлүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. Ар үр ахмадын сувилалд 409 ахмад эмчлүүлснээс,	30,5

					ХБИ-2, ганц бие-2 ахмад нийт 4 хүнд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлсэн байна. Анхан шатны ЭМБ-аар дамжуулан ахмад настны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, 625 ахмадыг хамруулсан. Нийт 1034 ахмадыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалаар болон нийгмийн хариуцлагын хүрээнд хөнгөлөлттэй тусламж үзүүлсэн байна.	
Арга хэмжээ 1.2.10 Осол гэмтэл өвчлөл ялангуяа хүүхдийн түлэгдэлт, гэмтэл, амиа хорлох, нас баралтаас сэргийлсэн мэдээлэл сургалт сурталчилгаа, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх	Улсын төсөв	Осол гэмтлийн тохиолдол 10000 хүн амд	141.6	135.5	Бага насны хүүхдийг аливаа осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, тохиолдлыг бууруулах чиглэлээр Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан “Зөвийг хэвшүүлье” арга хэмжээний хүрээнд салбар дундын уулзалт арга хэмжээ 3 удаа зохион байгуулагдаж 6 байгууллагын хамтран баталсан төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Осол гэмтлийн сарын аян зохион байгуулж, өрхийн эмнэлгүүдтэй хамтран бага насны хүүхдийг ахуйн осол гэмтлээс сэргийлэх талаар эцэг эхийн сургалт явуулж 30 хүнийг хамруулсан ба гарын авлага боловсруулан 100 гаруй хүнд тараасан. Он гарсаар 5 сарын байдлаар 436 хүн осол гэмтэлд өртсөж тусламж авсан нь 10000 хүн амд 59,7 байгаа ба 27 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 12 тохиолдлоор өсч, өвчлөл 218 тохиолдлоор буурсан байна. Он гарсаар 109 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 24,7% нь осол гэмтэл, үүнээс хүүхдийн түлэгдэлтээр 1 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.	50
Арга хэмжээ 1.2.11. Салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот арга хэмжээ (“Хавдрын эсрэг арга хэмжээ”, “Эрүүл чийрэг эр хүн”, “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээ гэх мэт)-г үр дүнтэй хэрэгжүүлэх	Улсын төсөв	Арга хэмжээний дундаж хэрэгжилтийн хувь	70.0	90.0	2022 онд Улсын хэмжээнд хавдрын тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор салбар дундын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулагдсан. Орон нутгийн хэмжээнд уулзалт арга хэмжээг 3 удаа зохион байгуулсан. Он гарсаар хавдрын өвчлөл 12, нас баралт 16 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нас баралт 8 тохиолдлоор буурсан байна. Өнгөрсөн онд аймгийн хэмжээнд хагас жилийн байдлаар хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын шалтгаанаар 2-рт эрэмбэлэгдэж байсан бол 2022 онд 3-рт орж нас баралт харьцангуй буурч байна. Энэ нь улс, орон нутгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэг эхлүүлсэн, мөн иргэд цар тахалын дараах эмнэлгийн тусламж үйлчилгээ авах нөхцөл бүрдэж үзлэг эмчилгээнд хамрагдалт нэмэгдэж байгаатай холбоотой байна. Илүүдэл жингүй эртэч	40

						Монгол” аяныг БТСГ болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан бөгөөд идэвхитэй оролцсон байгууллага-27 бол цахимаар оролцсон хүний тоо-2500, танхимаар-15,000, үүнээс алхсан-4523, гүйсэн-8545, дугуй унасан-285, гадаа дасгал хийсэн -3821 нийт 32174 хүн оролцсон байна. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний хүрээнд ӨЭМТөвд түрүү булчирхайн томролтыг тодорхойлох түргэвчилсэн оношлуур, түрүү булчирхайн хавдрын маркер үздэг болсон.	
	Арга хэмжээ 1.2.12. Хавдраас сэргийлж, хорт хавдрыг эрт илрүүлэх, эмчлэх амьдрах хугацааг уртасгах, хүүхдийн хавдар өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулах	Улсын төсөв	Арга хэмжээний дундаж хэрэгжилтийн хувь	50,0	80.0	Орон нутгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийг “Явуулын үзлэг”, “Явуулын оффисс” арга хэмжээний хүрээнд зохион байгуулж байна. Үзлэг арга хэмжээнд нийт 5 сумын 15 багт ажиллаж 1982 хүнийг 6356 төрлийн үзлэг, оношилгоонд хамруулсан.	50
	Арга хэмжээ 1.2.13. Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, хандлагыг өөрчлөх, мэдээлэл сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, бусад салбарын хамтын оролцоог уялдуулан чиглүүлэх	Улсын төсөв	МСС-д хамрагдсан байгууллагын тоо иргэдийн тоо хамтран ажилласан байгууллагын тоо	40 47000 21	56 50000 30	Эрүүл мэндийн газрын пэйж хуудсанд иргэдэд зориулсан мэдээ, мэдээлэл, сурталчилгааны материалыг тогтмол байршуулж, 14 заалт бүхий МСС төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар ЭМГ пэйж хуудсанд 187 пост, 8 түүх, 41686 хандалт, 1984 лайк, 71 сэтгэгдэл, 1002 шэйр хийгдсэн байгаа бол МСС-ны төлөвлөгөөний хэрэгжилт 42%-тай байна. Мөн шударга өрсөлдөөн хэрэглэгчийн газартай хамтран 5 сургуулийн 300 хүүхдэд электрон тамхины хор нөлөө, хэрэглээний аюултай талыг ойлгуулах мэдээлэл, танилцуулга хийж, 4 зурагт хуудсыг боловсруулан, аймгийн хэмжээний нийт 20 сургуулийн цахим мэдээллийн сүлжээнд оруулж, 15,000 эцэг эх ЭМГ-ын танилцуулгыг цахимаар хүлээн авч танилцсан. Давсны долоо хоногийн хүрээнд 15 сумын ЭМТ-үүдээр дамжуулан, давсны хэрэглээг бууруулах ач холбогдлын талаар цахим сурталчилгааг зохион байгуулж, 4750 хүний хандалт авч, 600 иргэнд	81,9

						сурталчилгааны материал тарааж, 19 айлд давсны хэрэглээний хэмжилт хийн зөвлөмж өгч ажилласан байна. МСС-д хамрагдсан байгууллагын тоо-35/62,5 иргэдийн тоо- 41686/ 83,3%, хамтран ажилласан байгууллагын тоо- 50/100%	
	Арга хэмжээ 1.2.14. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, хувийн хөрөнгө оруулалтаар спорт, бялдаржуулах клуб, нийтийн бүжиг, эрүүл зөв амьдралын хэв маягийг ард иргэдэд хэвшүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.	ОНТөсөв 15.0 сая төг.	Хамтран ажилласан төрийн бус байгууллага, нийгэмлэг, холбооны тоо	0	2	“Илүүдэл жингүй эртэч Монгол” аяныг БТСГ болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан бөгөөд идэвхитэй оролцсон байгууллага-27 бол цахимаар оролцсон хүний тоо-2500, танхимаар-15,000, үүнээс алхсан-4523, гүйсэн-8545, дугуй унасан-285, гадаа дасгал хийсэн -3821 нийт 32174 хүн оролцсон байна. Мөн Дугутай Өмнөговь, Эрүүл мэндийн салбарын нэгдсэн өдөрлөг арга хэмжээг ТББ болон бүжиг, дугуй, иога, тулааны спортын клубүүдтэй хамтран зохион байгуулахаар удирдамжаа батлуулсан ба бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд эхний байдлаар 5000 хүнийг хамруулах төлөвлөлттэй байна.	100
Зорилт 1.3. Уур амьсгалын өөрчлөлт, орчин болон хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.							
1.3.	Арга хэмжээ 1.3.1. Орчны эрүүл мэндийг хангах, агаарын бохирдол, тоосжилт, хөрсний бохирдол, хөл ургамлаас шалтгаалсан харшлын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор “Харшлын эсрэг хөтөлбөр” -ийг хэрэгжүүлж, хүн амын эрүүл мэндийг хамгаална.	ОНТөсөв 50.0 сая төг	Бохирдуулах бодисын бууралт РМ 2.5 тоосонцор	100.0 мкг/м³	110.0 мкг/м³	Харшлын эсрэг” хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн 50 сая төгрөгний санхүүжилттэйгээр үйл ажиллагаа эхлүүлээд байна. Төлөвлөгөөний дагуу 2022 оны 7 сард “Шарилжгүй Даланзадгад” аяныг хэрэгжүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна. БОЭТ-ийн арьс харшлын эмчтэй хамтран аймгийн хүн амын дунд арьс харшлын явуулын үзлэг зохион байгуулж байна. Мөн Харшлын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд Харшил өвчний тухай ойлголт тархалт, Астма өвчний эмнэл зүй, оношлогоо эмчилгээ хяналт, Харшлын сорил тавих үнэлэх, уушигны багтаамж үзэх, иргэдэд зориулсан Астма өвчний удирдамжийн гарын авлага зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулагдаж байна. Аймгийн ӨЭМТ-ийн салбар зөвлөлийн урилгаар АУ-ны доктор, АШУҮИС-ийн уушиг, харшил судлалын тэнхимийн дэд профессор, ЭМЯ-ны дотор өвчин судлал мэргэжлийн салбар зөвлөлийн	35

						гишүүн Б.Солонго, АУ-ны магистр, АШУҮИС-ийн АУС-ийн уушиг харшил судлалын тэнхимийн багш Н. Түвшинтөр, АШУҮИС-ийн АУС-ийн уушиг харшил судлалын тэнхимийн судлаач Г.Түмэнэлзий нар сургалтыг удирдан явуулж байна. ӨЭМТөвд хяналтанд байдаг харшилтай, астма өвчтэй иргэдэд үзлэг хийж онол дадлагын хосолсон сургалтыг явуулсан. ӨЭМТөвүүдэд Харшлын сорил тавихад шаардлагатай харшлын багцын 15 төрлийн оношлууртай, харшлын сорил тавих, уушигны багтаамж үзэх Пикфлоуметрийн багажтай болсон. ДЭМБ Цаг уурын газар мэргэжлийн хяналтын газруудтай хамтран сүүлийн жилүүдийн агаар ус хөрсний бохирдлын шинжилгээ судалгааг хийсэн ба РМ 2.5 тоосонцор стандарт хэмжээнээс давсан үзүүлэлттэй гэсэн дүгнэлт гарсан.	
	Арга хэмжээ 1.3.2. Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Ундны ус, ариун цэврийн байгууламжийн төлөвлөгөө хэрэгжүүлэх, стандартын дагуу жорлон, муу усны нүх барьж, ашиглах, нийтийн эзэмшлийн зам, талбайг эрүүл, цэвэр байлгах хөдөлгөөн өрнүүлж ажиллах.	Орон нутгийн төсөв	Усны аюулгүй байдлын төлөвлөгөө ний хэрэгжилтийн хувь	85.0	90.0	Өмнөговь аймаг 4 сав газрын хүрээнд уст цэг, ус бохирдуулагчийн тооллого хийх маршрут, шатахууны тооцоо судалгааг гарган нэгтгэж ажил гүйцэтгэх гэрээний төслийг боловсруулах шатандаа явж байна. Мандал-овоо, Манлай, Номгон, Ханбогд, Ханхонгор, Хүрмэн, Цогт-овоо, Цогтцэций, Баян-овоо, Булган сумдын ундны усны эх үүсвэр дээр ус цэнгэгжүүлэх, эрдэс бууруулах, халдваргүйжүүлэх тоног төхөөрөмж суурилуулах ажлыг орон нутгийн төсвөөр гүйцэтгүүлж байна. Баруун сумдын усны нөөц ашиглалтанд хяналт тавих мониторингийн багажийг 4G сүлжээнд холбох ажлын даалгавар боловсруулан худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Номгон, Баяндалай, Цогт-Овоо, Цогтцэций сумдын ногоон байгууламжийн усалгаа арчилгаанд дэмжлэг үзүүлэхээр 10 тонны 2 машин, 5 тонны 2 автомашиныг нийлүүлж нийтийн эзэмшлийн зам, талбайг цэцэрлэгжүүлэх, тохижуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 326 дугаар тогтоолоор "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ, ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээг тогтоох тухай журмын хүрээнд Эрүүл мэндийн байгууллагуудын цэвэр, бохир усанд шинжилгээ хийх ажлыг Мэргэжлийн хяналтын газрын лабораторитой хамтран зохион байгуулж ажилласан. Нийт 13	45

						байгууллага шинжилгээний дээжийг хүлээлгэн өгч хамруулсан. Нийт 13 заалт бүхий төлөвлөгөөний хэрэгжилт 45% тай хийгдсэн.	
	Арга хэмжээ 1.3.3. Анхан шатны эрүүл мэндийн төвүүдийн мобайл технологийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалт, зарим нэмэлт төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.	Төсөл хөтөлбөр	Тоног төхөөрөмжийн хэрэглээний хувь	70.0	85.0	Анхан шатны сум өрхийн эрүүл мэндийн төвийн 17 байгууллагад мобайл технологи бүрэн нэвтрүүлсэн бөгөөд 100% ашиглалттай байна. 2022 оноос зарим сумдад засвар шинэчлэлийн ажил, ашиглалтыг сайжруулах, эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах арга зүйн сургалтыг 3-р улиралд зохион байгуулахаар төлөвлөөд байна. Орон нутгийн “Явуулын оффисс” арга хэмжээ 5 сумын 15 багт ажиллаж байгаа бөгөөд тус арга хэмжээнд сумын эрүүл мэндийн төвөөс багийн иргэдэд мобайл технологи ашиглан 8 багт 354 хүнийг үзлэгт хамруулж зөвлөгөө өгөөд байна.	80
Стратегийн зорилго 2. Хүн амд зонхилон тохиолдож буй өвчлөл, эндэгдлийг бууруулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг сайжруулах							
Зорилт 2.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах							
2.1.	Арга хэмжээ 2.1.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдал, нөөцийн бэлэн байдлыг хангах	Улсын төсөв	Хамрагдсан иргэдийн хувь Нөөцийн хувь	2021 оны жилийн эцсийн хувь	гүйцэтгэлээр	2022 оны эхний хагас жилийн байдлаар Өмнөговь аймагт Коронавируст халдвар /КОВИД-19/-ын нийт батлагдсан тохиолдол 12833 байна. Үүнээс насанд хүрэгчид-9931/83.9%/, хүүхэд-1902/16.1%/- байна. Нийт тохиолдолуудаас уул уурхай, бүтээн байгуулалтын компани-3844/30%/, хилийн боомт-2234/17.4%/, Даланзадгад сум-2680/20.9%/, сумдууд-4075/31.8%/-г эзэлж байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нийт батлагдсан тохиолдолоос гэрийн эмчилгээнд-6547, эмнэлэгт-1705 иргэдийг хэвтүүлэн эмчилж эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна. Эрүүл мэндийн байгууллагууд халдварт өвчний дэгдэлт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж нөөцийг тогтмол хангуулан ажиллаж байна.Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын дагуу ковидын халдвар илрүүлэх шинжилгээнд үнэ төлбөргүй хамрагдах зорилтот бүлгийн шинжилгээнд	87

					шаардлагатай түргэвчилсэн оношлуур, эмнэлгийн хэрэгслийг ЭМГ-ын нөөцөөс 7 удаа бүрдүүлж ажилласан ба нийт 3600 ширхэг түргэвчилсэн оношлуур болон эмнэлгийн хамгаалах хэрэгсэл ариутгал халдваргүйтгэлийн бодисын 39,329,468 төгрөгийн нөөцийг ханган ажилласан. Шинжилгээний цэгээр 2022.01.01 - 2022.04.01-ны хооронд 3369 иргэнд шинжилгээ хийгдсэн. АОК-н нөөцөөс хангасан 2550 ширхэг 30,600,000 төгрөгийн үнийн дүнтэй түргэвчилсэн оношлуурыг ЭМГ-н даргын 2022 оны А/09 тоот тушаалаар сумдын зорилтот бүлгийн иргэдийн шинжилгээнд зориулан 14 сумын ЭМТ-д хуваарилан түгээсэн. ЭМС-н 2022 оны А/134 дугаар тушаалаар хуваарилагдсан 202,003,595 төгрөгийн эм тариа хамгаалах хэрэгслийг татан авч ЭМГ-н даргын А/14 дугаар тушаалаар 20 Эрүүл мэндийн байгууллагад хуваарилан нөөцийг нэмэгдүүлсэн. Эхний хагас жилийн байдлаар нөөцийн хангалтын хувь 87%	
Арга хэмжээ 2.1.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх чиглэлээр гарч буй хууль, дүрэм, тушаал, зааврыг хэрэгжүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллах	Улсын төсөв	Хэрэгжилтийн хувь	-	90	ЭМЯ-аас зохион байгуулсан “Коронавируст халдварын нөхцөл байдал”, “SARS-Cov-2 вирусын омикран хувилбарын эсрэг хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах” сэдэвт цахим сургалтанд ЭМГ, БОЭТ, сум, өрхийн ЭМТ-ийн эмч, эмнэлгийн ажилчдыг хамрууллаа. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх хууль, дүрэм, журмыг тухай бүр ЭМБ-дад хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа ба Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/01 дугаар Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины нэмэлт тунгаар вакцинжуулах тухай, А/33 дугаар Шинэ коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай, А/36 дугаар Түр заавар шинэчлэн батлах тухай (КОВИД-19 Тандалт, сэргийлэлт, Хариу арга хэмжээ, Халдварын сэргийлэлт хяналт, Лабораторийн оношилгоо, Халдваргүйжүүлэлт хийх түр заавар), МУ-ын ЗГ-ын тогтоолоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-ийг цуцалж, Коронавируст халдварын тархалт буурсантай холбогдуулан ЭМС-ын А/36, А/203 дугаар Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшинд тохирсон хариу арга хэмжээг шинэчлэх тухай, А/207 дугаар	95

					Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшинг үнэлэх түр заавар батлах тухай, А/282 дугаар, Гадаадын жуулчдад коронавируст халдвар (КОВИД-19)-ын тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар батлах тухай тушаалуудыг тус тус эмнэлгүүдэд танилцуулан арга зүйгээр ханган ажиллаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Хэрэгжилтийн хувь 95%	
Арга хэмжээ 2.1.3. Анхан шатны эрүүл мэндийн төвүүдийн мобайл технологийн тусламжийн алслагдсан нутаг дэвсгэрт суурьшиж буй малчид, иргэдийн хамралтыг нэмэгдүүлэх	Төсөл хөтөлбөр	Мобайл технологийн тусламжид хамрагдсан иргэдийн тоо		4200	Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагууд мобайл технологийг ашиглан явуулын үзлэг оношилгоог зохион байгуулж, одоогоор 8 сум, 3 ӨЭМТ нь 580 иргэд, малчдыг хамруулаад байна. Аймгийн засаг даргын Нутгийн хишиг хөтөлбөрийн “Эрүүл Өмнөговь” зорилтын хүрээнд 4 сарын 12-оос эхлэн Манлай, Баяндалай, Булган. Номгон, Цогт-Овоо, Сэврэй суманд лавлагаа шатлалын нарийн мэргэжлийн эмч нарийн баг ажиллаж, илрүүлэг үзлэг оношилгоог 1682 хүнд хийсэн ба цаашид бүх сумдаар үргэлжилэн хийгдэнэ. Нийт үзлэг оношлогоо тусламжид хамрагдсан иргэд малчдын тоо- 2262 / 53,8%	53,8
Арга хэмжээ 2.1.4. Эмнэлгийн тусламж үйлчилгээг “Үйлчлүүлэгч төв”-тэй байхаар зохион байгуулж, оношилгоо эмчилгээний удирдамж, стандартыг шинээр нэвтрүүлж, иргэдэд сэтгэлд хүрсэн тусламж үйлчилгээг хүргэх	Улсын төсөв	Удирдамж стандартыг хэрэгжүүлж буй ЭМБ-н хувь Иргэдийн эерэг сэтгэл ханамжийн хувь	83,5%	Гүйцэтгэлээр 85%	Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар батлах тухай, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн ерөнхий нэршлийн жагсаалт, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ, Даатгуулагчийг элэгний В,С вирусын илрүүлэг, шинжилгээнд хамруулах, даатгалын сангаас зардлын төлбөрийг санхүүжүүлэх журам, Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журам зэрэг 2022 онд батлагдсан, үйлчлүүлэгчдэд ээлтэй журам, удирдамжуудыг нийт эрүүл мэндийн байгууллагууддаа танилцуулан хэрэгжүүлэх тал дээр арга зүйгээр ханган ажиллаж байна. ЭМХТ-тэй хамтран БОЭТ-р үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжын судалгаа авч байгаа ба судалгааны нэгдсэн дүн 6 сарын сүүлчээр гарна.	40
Арга хэмжээ 2.1.5. Яаралтай тусламж үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх, “Нисдэг баг” үйлчилгээг үзүүлэх	50.0 ОНТөсөв 450,0	Яаралтай тусламж үйлчилгээнд хамрагдсан	2021 оны хувь	2022 онд хүрэх хувь	Түргэн тусламжийн 4023 дуудлагад явж үйлчилсний 588/16.2%/ нь алсын дуудлага, 203/5.6%/нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 77.4%-д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар БОЭТөвд иж бүрэн тоноглогдсон 153,819,000 төгрөгний	45

		Төсөл, хөтөлбөр	тоо, Нисдэг багийн үйлчилгээн ий тоо			түргэн тусламжийн автомашиныг шийдвэрлэж яаралтай тусламж үйлчилгээний чадавхийг дээшлүүлж автомашины шинэчлэл хийгдсэн. Түргэн тусламжийн парк шинэчлэлтэд 5 ширхэг тоноглогдсон ланд-76 автомашин тендер зарлаж гэрээг байгуулаад байна.	
Зорилт 2.2 Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эх, хүүхдийн эндэгдэл, үр хөндөлтийг бууруулах							
	Арга хэмжээ 2.2.1. “Эх хүүхдийн эрүүл мэнд” аймгийн хөтөлбөрийг тусгай төлөвлөгөөний хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлэх	ОНТөсөв 80.0 сая төг	Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт	2021 түвшин	2022 түвшин	“Эх, хүүхдийн ЭМ” хөтөлбөрийн 2022 оны төлөвлөгөөг 15 үйл ажиллагаа зохион байгуулахаар батлуулсан ба эхний хагас жилд хийгдэх 9 ажлын биелэлт 70 хувьтай байна. Санхүүжилтийн хувьд зарцуулалт бага хийгдсэн хэдий ч үйл ажиллагааны биелэлт хангалттай хийгдсэн. Багаж тоног төхөөрөмж, эм хэрэгслийн худалдан авалт хугацаа шаардаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт, онол практикын хурал, зөвлөгөөнүүдийг зохион байгуулсан.	70
2.2.	Арга хэмжээ 2.2.2. НҮЭМ-ийн кабинетын үйл ажиллагааг тогтмолжуулж, АШЭМБ-ын эмч, мэргэжилтнүүдийн ГБТ-ийн зөвлөгөө өгөх үр чадварыг дээшлүүлж, нууцыг хадгалах, чирэгдэлгүй үйлчлэх	Улсын төсөв	1. Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь	90	92	НҮЭМ-ийн кабинетын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлийг БОЭТ-д зөвлөмж хүргүүлж, тусламж үйлчилгээ үзүүлэх эмчийг тусгайлан томилон ажиллуулж байгаа ба нийт 78 эмэгтэйд тус кабинетаар тусламж үйлчилгээг үзүүлээд байна. Сум өрхийн эмнэлгээр 7422 эмэгтэй гэр бүл төлөвлөлт, НҮЭМ-н чиглэлээр тусламж үйлчилгээнд хамрагдсан. ГБТ, НҮЭМ-ийн зөвлөгөө өгөх үр чадварт сургагч багшаар бэлтгэгдсэн орон нутгийн эмч нар сум, өрхийн эмч, эх баригч нарт цахим сургалт хийж зөвлөгөө өгөх үр чадварыг нэмэгдүүлж ажилласан. 2022 оны 5 сарын байдлаар 720 эх жирэмсний хяналтанд орсноос 661 буюу 91,8% эрт хяналтад хамрагдсан байна. Нийт 9765 эмэгтэйд жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглүүлж байгаа нь нийт төрөх насны эмэгтэйчүүдийн 51% эзэлж байна.	100
			2. ЖСА хэрэглээний хувь /НҮНЭ-ийн дунд эзлэх хувь/	47	50		
	Арга хэмжээ. 2.2.3. Эхчүүд, эмэгтэйчүүдийн суурь өвчлөлийг эрүүлжүүлэх, хянах	Улсын төсөв	Суурь өвчтэй НҮНЭ-ийн хувь	2021 оны хувь	90	НҮНЭ-ийн суурь өвчлөлийг илрүүлэх, эмчлэх арга хэмжээг “Эрүүл Өмнөговь” хөтөлбөрийн үзлэгийн явцад хийхээр баг бүрт эх барих эмэгтэйчүүдийн эмч ажиллуулж байгаа ба , одоогоор 3 сумын 800 гаруй эмэгтэйчүүдийг үзлэгт хамруулж, зөвлөгөө өгөөд байна. Нийт үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн 31% нь ямар нэг суурь өвчтэй	22

			Эрүүлжсэн хувь			байгаа ба сумын эрүүл мэндийн төвтэй хамтран эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.	
	Арга хэмжээ 2.2.4. Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэх, жирэмсний хяналтын чанарыг сайжруулан, жирэмсэн үеийн халдварын илрүүлэг шинжилгээний хамралт, эмчилгээ, хяналтын байдалд хяналт тавих	Улсын төсөв	Хамралтын хувь	2021 оны хувь	90	Жирэмсний эрт хяналтын хувийг жилээс жилд тогтвортойгоор нэмэгдүүлэн ажиллаж байгаа бөгөөд гол нь эмч, мэргэжилтнүүдийг тасралтгүй сургах, чиглүүлэх ажлыг 7 хоног бүрийн 4 дэх өдөр зохион байгуулж, анхан шатны ЭМБ-ын эмч, мэргэжилтнүүдтэй цахим хурал зохион байгуулж байна. Жирэмсний үеийн шинжилгээнд шаардлагатай тест, урвалж оношлуурыг тасралтгүй ханган ажиллаж байна. Жирэмсний нэрийн хяналт хийх хөдөлгөөнт самбарыг Жирэмсний зөвлөгөө өгөх кабенитад байрлуулж, хөтөлж хэвших ажлыг орон нутгийн хөтөлбөрийн хүрээнд хийж эхлүүлээд байна. Нийт хяналтанд орсон 720 жирэмсэн эхчүүдийн 92 хувийг эрт үеийн хяналтад хамруулсан ба халдварын шинжилгээнд 99,8% тай хамруулж, БЗДХ-н 4 тохиолдлыг эрт илрүүлж эрүүлжүүлэх арга хэмжээг авснаар төрөлхийн тэмбүү гаргаагүй ажилласан.	95 %
	Арга хэмжээ. 2.2.5. Төрөх үеийн эх барих болон нярайн эрт үеийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, 0-28 хоногтой нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулах	Улсын төсөв	Нярайн эндэгдлийн хувь Нярайн эндэгдэлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	72,2 7,9	65 7	Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор ЭХЭМҮТ-тэй хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг гарган хүргүүлсэн. Эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлгийн 1 эмчийг жирэмсний эмгэгийн тасагт ажиллуулах бэлэн байдлыг ханган, жирэмсэн төрөх үеийн эрчимт эмчилгээний эмчийг 3 сарын сургалтад ЭХЭМҮТ-д сургасан. КОВИД-19 батлагдсан жирэмсэн эхчүүдийн тасгийг тусад нь гарган, эх барихын мэргэжлийн эмч нарын багийг улаан бүсэд ажиллуулснаар эх, нярайн эрсдэлгүй цар тахлын давалгааг даван туулсан. 2022 онд КОВИД-19 халдвартай 190 жирэмсэн эмэгтэйд тусламж үйлчилгээ үзүүлж, эсэн мэнд амаржуулаад байна. Мөн Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хэрэгжилтийг нэмэгдүүлж, кесар мэс заслаар төрсөн эх, нярайг арьс арьсаар нь шүргэлцүүлж, төрөхийн өмнө өрөөнд ар гэрийг нь байлцуулан, асаргаа үзүүлэх боломжоор ханган ажиллаж байна. 2022 оны 5 сарын байдлаар 7 нярай эндсэн нь нийт нялхасын эндэгдэлийн 70% эзэлж байгаа ба 1000 амьд төрөлтөд 15,4 байна.	50%

Арга хэмжээ 2.2.6. Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд эцэг эхийг сургах, байгууллага, хамт олны хамтын ажиллагааг сайжруулах замаар өвчлөл, эндэгдлийг бууруулах	Улсын төсөв	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	0,7	0,5	Аймгийн ЭМГ-аас Хүүхдийн сантай хамтран 65.0 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлж, БОЭТ-ийн Хүүхдийн тасгийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан. Даланзадгад суманд 3 ӨЭМТ-д 36, СЭМТ-дэд 47 нийт 83 олон нийтийн эрүүл мэндийн ажилтаныг сонгон шалгаруулж, хувцас цүнх, эм эмнэлгийн хэрэгсэлээр хангалаа. НҮБ-н Хүүхдийн Сантай хамтран эцэг эхчүүдэд зориулсан брошур нийт 2000 гаруйг ЭМТөвүүдэд хуваарилан олгов. Мөн 2022 оны томуугийн удирдамж ном 40 ш-ийг ЭХЭМҮТ ЭМЯ-тай хамтран бүх ЭМБ –дад хуваарилан олголоо. УБ хотод Тогтвортой хөгжил-Хүүхдийн эрүүл мэнд улсын зөвлөгөөнд ЭМГ, БОЭТ-өөс 2 мэргэжилтэн оролцож цаашдын ажлын чиглэлээр хангасан. 2022 оны 5 сарын байдлаар 453 хүүхэд төрж, 1909 хүүхэд стационарт хэвтэн эрүүлжиж гарсан. 1-5 насны 2309 хүүхэд идэвхитэй хяналтанд хамрагдаж, 1481 хүүхэд Д \витамин, 176 хүүхэд ОНБТ хэрэглэсэн. 2062 хүүхдийг хэмжилт хийж, 89.3 хувьд нь хийгдсэн байна. Мэдээлэл сургалт сурталчилгааг өрхийн ЭМТ, сумын ЭМТөвөөс нийт 63 удаа хийж, 5000 гаруй эцэг эхчүүдийг хамрууллаа. 1-5 хүртэлх насны 2 хүүхдийн эндэгдэл тохиолдсон ба цусны хавдар, үам тээврийн осолын шалтгаантай эндсэн байна. Эндэгдэлийн түвшин 1000 амьд төрөлтөд 4,4 байгаа ба хүүхдийн эндэгдэлийг гаргахгүй тохиолдолд оны эцэст гэрээний түвшинд хүрч болох үзүүлэлт юм. Энэ чиглэлээр эмнэлгүүдэд арга зүйгээр ханган ажиллаж байна.	15
		0-1 хүртэлх насны нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	10,2	9,5	УБ хотод Нярайн эрүүл мэнд сургалтад 3 эмч мэргэжилтэнийг хамруулсан. Нярайн эмгэгийн тасгийг 4 эмч, 4 сувилагчтай ажиллуулж байна. Орон нутгаас нярайн сурфактантаар тасралтгүй хангаж байна. ЭМЯ-ны багтай хамтран төрөх тасагт 5 хоногийн ажлын байрны хяналт үнэлгээ сургалтыг хийж, зөвлөмжийг хүргүүлсэн. Нялхсын эндэгдэл 21,9 болж өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн.	40
	Төсөл хөтөлбөр	Ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл	-	98	Хүүхдийн сантай аймгийн ЗДТГ, ЭМГ хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. ОНЭМА-ыг чадавхижуулах, ХӨЦМ-ийн сургалтуудыг хийхээр төлөвлөөд байна. Мөн агаарын бохирдлыг бууруулах төсөлд 10 айл хамрагдсан. Агаарын чанарыг хэмжих	33,3

						багаж төхөөрөмжөөр ЭМБайгууллагуудыг хангах төсөл батлуулсан ба хамтын ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 33,3% байна.	
	Арга хэмжээ 2.2.8. Өрх сумын эрүүл мэндийн төвд 18 болон 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг тогтмол зохион байгуулах /ХНХС/БСШУС/ЭМС-ын 2018 оны А/304/699/460-р тушаал	Улсын төсөв	Тухайн жилд төлөвлөсөн үзлэгийн хувь	-	90	Сум өрхийн ЭМТ-үүд 18 болон 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц /ХНХС/БСШУС/ЭМС-ын 2018 оны А/304/699/460-р тушаалын хүрээнд зохион байгуулж байна. Мөн ХБХүүхдийг илрүүлэн эмч нарын Хүүхдийн комиссоор оруулан зэргийг тогтоон ХХҮГ-аас тэтгэмж олгож байна. Одоо ний 2330 хүүхэд хамрагдаад байна.	20
	Арга хэмжээ 2.2.9. Эх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулахад Оюу толгой ХХК, НҮБ-ийн ХАС болон төр, ТББ-тай хамтран ажиллах	Төсөл, хөтөлбөр	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	95	НҮБХАС, Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилттэй 2018-2021 онд хэрэгжүүлсэн Нэгдсэн хөтөлбөрийг 2022-2025 онд дахин хэрэгжүүлэхээр төлөвлөгөөний төсөл гарч, батлагдахад бэлэн болсон ба уг хөтөлбөрийн 1 зорилтод эх, хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах заалтыг оруулсан.	10
	Арга хэмжээ 2.2.10. Өсвөр үе, залуучуудад ээлтэй кабинетуудын НҮЭМ-ийн тусламжийн чанар, эм хэрэгслийн хангалтыг сайжруулах	Улсын төсөв	Нийт төрөлтөд өсвөр насны охидын жирэмслэлт, төрөлт, үр хөндөлтийн хувь	6.1	5.6	Өсвөр үеийн кабинетын тоог нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд сум бүрт өсвөр насныханд тусламж үйлчилгээ үзүүлэх боломж бүхий өрөөг гаргах чиглэл өгч, эмч, эх баригч нар өсвөр насныханд зөвлөгөө өгөх ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг 6 сард зохион байгуулсан. Ингэснээр тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ. Тендерийн эм хэрэгслийн захиалгад өсвөр үеийн кабинетад шаардлагатай эм хэрэгслийг захиалж, нийлүүлж байна. Нийт 14 охид үр хөндүүлж, 23 охин төрсөн нь нийт үр хөндөлт, төрөлтийн 6,2 хувь эзэлж байна. / Үр хөндөлт 7.4, төрөлт 5, дундажаар 6,2/	75%
	Арга хэмжээ 2.2.11. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Гашуун сухайт боомт дахь ЗӨСТөв, Гурвантэс сумын ПГУ МБЛабораторийг урвалж бодисоор хангах, тасралтгүй жигд үйл ажиллагааг хангаж ажиллах	Улс, орон нутгийн төсөв, ЭМД, төлбөрт үйлчилгээ	Урвалж, оношлуураар хангагдсан лаборатори	2	3	БОЭТ, Гурвантэс сумын ЭМТ-н захиалгын дагуу Ерөнхий гэрээний нөхцлөөр ялгах кит, ПГУ оношлуур дагалдах хэрэгслийг 3 эм ханган нийлүүлэх байгууллагаас 5 удаагийн захиалгаар 75 662 400₮-н 6000 ширхэг оношлуурыг гэрээ байгуулан татан авалтыг хийж, шинжилгээний тасралтгүй байдлыг ханган ажилласан. БОЭТ болон сум өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай 7750 ширхэг антиген суурьтай түргэвчилсэн оношлуурыг аймгийн нөөцөөс шийдвэрлэн	100

						олгосон. Урвалж оношлуураар хангагдсан лабораторийн тоо 2. 2022 оны 5 сарын байдлаар БОЭТ-д 5000 гаруй, гашуун сухайт лабораторид 68000 гаруй ПСР шинжилгээ, 24 шинжилгээний цэгээр 21309 удаагийн түргэвчилсэн шинжилгээ хийгдсэн.	
